“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК-ИЙН ХАРЬЯА НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА БОЛОН НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА ХООРОНДЫН ХАРИЛЦАН АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ

БАРИМТ БИЧГИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ

	Албан тушаал, нэр, гарын үсэг	Огноо
БАТАЛСАН:	“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ..... Б.ОТГОНСҮХ	2025-12-09
ХЯНАСАН:	“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК-ИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА ..... П.ГАНТӨГС	2025.12.26
БОЛОВСРУУЛСАН:	“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК-ИЙН АГААРЫН НАВИГАЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА ..... Д.БАЯРТОГТОХ	

ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

№	Боловсруулсан огноо	Өөрчлөлтийн товч утга	Хамаарах хэсэг, хуудас
1 -р хэвлэл	2024	Анхны хувилбар	Бүгд
2-р хэвлэл	2025	1) Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 193 дугаар тогтоолоор "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК байгуулагдаж, Зам, тээврийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/290 дугаар тушаалын дагуу компанийн бүтэц зохион байгуулалт шинэчлэн батлагдсантай холбоотой өөрчлөлтүүдийг оруулав. 2) Товчилсон үгсийн тайлбарт: • АУНМҮХ – АҮҮХ • ЭХАТМЗХ – НМАДМҮХ болж өөрчлөгдөв. 3) mcaa.gov.mn И-мэйл хаяг болон сайтууд ncac.mn болж өөрчлөгдөв. 4) Журмыг хариуцах ажилтнуудын нэр, утасны дугаарт өөрчлөлт оров.	Бүгд

Агуулга	Хуудас
Баримт бичгийн баталгаажуулалт	
Өөрчлөлтийн бүртгэл	1
Гарчиг	2
1. Ерөнхий зүйл	3
1.1 Зорилго	3
1.2 Үндэслэл	3
1.3 Нэр томьёо, тодорхойлолт	3
1.4 Товчилсон үгсийн тайлбар	3
2. Харилцан ажиллагаа	4
2.1 Нислэгийн урсгал төлөвлөлтийн албаны хариуцах үйл ажиллагаа	4
2.2 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны хариуцах үйл ажиллагаа	6
3. Бусад	
3.1 Журмын үл тохирлыг илтгэх	7
3.2 Журмын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, дүгнэх	7
3.3 Журамд өөрчлөлт оруулах	7
3.4 Журмыг хариуцагчид	8
3.5 Хавсралт	8

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Үндсэн зорилго

1.1.1 Энэхүү журмын зорилго нь ИНҮТ ТӨХХК-ийн Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба (цаашид НУТА гэх), Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба (цаашид НХҮА гэх) хоорондын харилцан ажиллагааг зохицуулахад оршино.

1.1.2 Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Үндэслэл

1.2.1 Энэхүү журам нь "Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ерөнхий заавар", "Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам"-ын шаардлагуудыг үндэслэн боловсруулагдсан болно.

1.3 Нэр томьёо, тодорхойлолт

1.3.1 Энэхүү журамд MNS 6409:2024-д орсон нэр томьёо, тодорхойлолтуудыг ашиглана.

1.4 Товчилсон үгсийн тайлбар

1.4.1 Энэхүү журамд дараах товчилсон үгсийг ашиглана. Үүнд:

а) Монгол үгс

- АБЧУГ Аюулгүй байдал, чанарын удирдлагын газар
- АУЦ Аэродромын удирдлагын цамхаг
- АУҮХ Аэродромын удирдлагын үйлчилгээний хэсэг
- БУҮХ Бүсийн удирдлагын үйлчилгээний хэсэг
- ОУҮХ Ойртолтын удирдлагын үйлчилгээний хэсэг
- ЭЕНХУ Ээлжийн ерөнхий нислэгийн хөдөлгөөний удирдагч
- НМА Нислэгийн мэдээллийн ажилтан
- ИНД Иргэний нисэхийн дүрэм
- ИНЕГ Иргэний нисэхийн ерөнхий газар
- ИНҮТ ТӨХХК "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК
- НБГО Нислэгийн бүртгэл, гүйцэтгэлийн оператор
- НТБГ Нислэгийн төлөвлөлт, бүртгэл, гүйцэтгэл
- НУТА Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба
- НУТБСБ Нислэгийн урсгал төлөвлөлт, бүртгэл, санхүүгийн биллинг
- НХУ Нислэгийн хөдөлгөөний удирдлага
- НХҮ Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ
- НХҮА Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба
- НЦХЗХ Нислэгийн цагийн хуваарь, зөвшөөрлийн хэсэг
- ОУНБ Олон улсын нисэх буудал

- ШТХ Шуурхай төлөвлөлтийн хэсэг
- НМАДМҮХ Нислэгийн мэдээлэл, аюулын дохио мэдээллийн үйлчилгээний хэсэг

б) Гадаад үгс

- MAAR Monitoring Agency for Asia Region
- TSD Traffic sample Data
- AFS Aeronautical fixed service
- ADP ATFM Daily Plan

2. ХАРИЛЦАН АЖИЛЛАГАА

2.1 Нислэгийн урсгал төлөвлөлтийн албаны хариуцах үйл ажиллагаа

2.1.1 Нислэгийн урсгал төлөвлөлтийн урт, урьдчилсан, шуурхай төлөвлөлтийн мэдээллээр НХҮА-ыг хангаж, харилцан ажиллана.

2.1.2 НХҮА-ны нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгжүүд /АҮҮХ, ОҮҮХ, БҮҮХ, НМАДМҮХ/-тэй харилцан ажиллана.

2.1.3 Нислэгийн урсгал төлөвөлтийн өөрчлөлтийн мэдээгээр НХҮ-ний нэгжүүдийг хангаж ажиллана.

2.1.4 Урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээг atfm.ncac.mn цахим хуудасны “Төлөвлөлт” цэсний “Урьдчилсан төлөвлөлт” хэсэгт байршуулна.

2.1.5 Урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээг НХҮА-ны ats_committee@ncac.mn цахим хаягаар хүргүүлнэ.

2.1.6 ATFMS сүлжээнд доголдол үүссэн тохиолдолд "Урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээ"-нд орсон нислэгийн өөрчлөлт болон шинээр төлөвлөгдсөн хуваарьт бус нэмэгдэл нислэгийн мэдээллийг ZMUBZRZX AFS сүлжээгээр тухай бүр дамжуулна.

2.1.7 Өнгөрөлтийн нислэг онцгой тохиолдлын буулт үйлдсэн тохиолдолд тухайн нислэгийн зөвшөөрөл хүчинтэй байна.

2.1.8 Нислэгийн бүртгэл, гүйцэтгэлийн оператор нь НХҮА-ны бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын нэгжүүдээс стрипийг 2 цаг тутамд авна.

2.1.9 Нислэгийн хөдөлгөөний удирдлагын стрип болон бусад шаардлагатай мэдээллийг АБЧҮГ-ын хүсэлтийг үндэслэн safety-atc@ncac.mn цахим шуудангийн хаягаар хүргүүлнэ.

2.1.10 Нислэгийн төлөвлөлтийн мэргэжилтэн нь урьдчилсан төлөвлөлтийн нислэгийн мэдээнд орсон нислэгийн өөрчлөлтийг тухай бүр НХҮА-ны БҮҮХ, ОҮҮХ, АҮҮХ, НМАДМҮХ хэсгүүдийн AFS сүлжээний хаягаар дамжуулна.

2.1.11 Нислэгийн төлөвлөлтийн мэргэжилтэн нь НХҮА-ны ээлжийн өмнөх зааварчилгаа ярианд дараах мэдээллийг өгнө. Үүнд:

1) Тухайн ээлжийн нислэгийн төлөвлөлт,
2) Онцгой үүрэг, тусгай үүрэг, албан захиалгат нислэгүүд,
3) Хилийн, дархан цаазат, тусгай хамгаалалттай газар нутгийн агаарын бүс зурваст үйлдэгдэх нислэгийн мэдээлэл,

2.1.12 Тухайн жилийн 12 дугаар сарын нислэгийн гүйцэтгэлийг өндрийн хамт MAAR-аас гаргасан форматын дагуу гаргаж safety-atc@ncac.mn цахим хаягаар дараа жилийн 1 дүгээр сарын 05-ны дотор АБЧУГ-т хүргүүлнэ. (Monitoring Agency for Asia Region /MAAR/-т илгээх Traffic sample Data /TSD/ мэдээлэл).

2.1.13 Агаарын хөлөг зөвшөөрөл олгосон агаарын хаалгаас өөр агаарын хаалгаар орох хүсэлтийг зэргэлдээх НХУ-ын төвөөс тавьсан тохиолдолд БҮҮХ-ийн ЭЕНХУ-аас 7128-1602 дугаарын утсаар хүлээн авч хариуг 7128-1618 утсаар мэдэгднэ.

2.1.14 Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам болон НҮТА-ны үйл ажиллагаатай холбоотой баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд, НХҮА-нд тухай бүр хүргүүлнэ.

2.1.15 Хяналтгүй агаарын зайд үйлдэгдсэн нислэгийн гүйцэтгэлийг хавсралт 1 –ийн дагуу НМАДМҮХ-ийн “Арцат” ажлын байрны НМА-аас tpu@mcaa.gov.mn цахим хаягаар хүлээн авна.

2.2 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны хариуцах үйл ажиллагаа

2.2.1 НҮТА-аас ирүүлсэн нислэгийн урсгал төлөвлөлтийн мэдээллийг зөвхөн үйл ажиллагаандаа ашиглах ба гадагш тараахгүй байх үүрэгтэй.

2.2.2 НМАДМҮХ-ийн “Арцат” ажлын байрны НМА нь “Чингис хаан” ОУНБ, “Буянт-Ухаа” ОУНБ болон орон нутгийн нисэх буудлуудад үйлдэгдсэн нислэгийн гүйцэтгэлийн мэдээллийг НҮТА-ны tpu@mcaa.gov.mn хаягаар дамжуулна.

2.2.3 AFS хаягаар (нисэх тооцоот цагаасаа 120 цагаас ихгүй хугацааны өмнө) ирсэн нислэгийн төлөвлөгөө (flight plan), түүний аливаа өөрчлөлт нь урьдчилсан төлөвлөлтөд тусгагдаагүй бол бүсийн нислэгийн мэдээллийн ажилтан нь НҮТА-ны

нислэгийн төлөвлөлтийн мэргэжилтэнд яаралтай мэдэгдэж нислэгийн зөвшөөрөлтэй эсэхийг баталгаажуулна.

2.2.4 НУТА-аас олгосон зөвшөөрлийн хүрээнд тухайн нислэгийн агаарын хаалга болон нислэгийн замын өөрчлөлтийн зохицуулалтыг БУҮХ-ийн ЭЕНХУ хийнэ.

2.2.5 Нислэгийн урсгал төлөвлөлтийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц нислэгийн хөдөлгөөний удирдлага, мэдээллийн үйлчилгээ, тоног төхөөрөмжид өөрчлөлт оруулах шийдвэр гарсан тохиолдолд тус өөрчлөлтийг НУТА-нд урьдчилан мэдэгдэнэ.

2.2.6 Нислэгийн төлөвлөлт, гүйцэтгэл бүртгэлийн ATFMS программыг НХҮА-ны ажлын байруудад ашиглах техник, тоног төхөөрөмжийг НХҮА нь хариуцан ажиллана.

2.2.7 НМАДМҮХ-ийн "Арцат" ажлын байрны НМА нь хяналтгүй агаарын зайд үйлдэгдсэн нислэгийн гүйцэтгэлийн мэдээг Хавсралт 1-ийн дагуу НУТА-ны ШТХ-т tpu@mcaa.gov.mn цахим хаягаар хүргүүлнэ.

3. БУСАД ЗҮЙЛ

3.1 Журмын хэрэгжилтийг үнэлэх

3.1.1 Талуудаас томилогдсон ажилтнууд нь журмын хэрэгжилтэд жилд 1-ээс доошгүй удаа дүн шинжилгээ хийж, тайланг АНҮГ болон АБЧУГ-т хүргүүлнэ.

3.1.2 Талууд журмын хэрэгжилтийг дүгнэсэн актын үнэлгээгээр илэрсэн үл тохирлыг залруулах, дахин давтагдахаас сэргийлэх зорилгоор тохирох арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

3.1.3 Шууд хариуцах ажилтнууд нь энэхүү журмын заалтууд хэрэгжээгүй аливаа тохиолдлыг шуурхай шийдвэрлэж, авсан арга хэмжээний талаар үндсэн хариуцагчид мэдэгдэнэ.

3.2 Үл нийцлийг мэдээлэх

3.2.1 Тус журмын зохицуулалттай холбоотой аливаа асуудлыг талуудын хариуцагчид бие даан шийдвэрлэх боломжгүй тохиолдолд удирдах дээд байгууллагаар шийдвэрлүүлнэ.

3.2.2 Харилцан ажиллагааны журмын зохицуулалттай холбоотой аюулгүй байдлын мэдээллийг АБЧУГ-т 7128-3116 88974030 дугаар руу эсхүл safety-atc@ncac.mn хаягаар шуурхай хүргүүлнэ.

3.3 Журамд нэмэлт өөрчлөлт оруулах

3.3.1 Талууд энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг АНҮГ-т гаргана.

3.3.2 Саналыг үнэлж нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг журамд оруулна.

3.3.3 Талууд журамд тусгагдсан утас, цахим шуудангийн хаягт өөрчлөлт орсон тохиолдолд үндсэн хариуцагчид мэдэгдэнэ.

3.4 Журмыг хариуцагчид

3.4.1 Хариуцах албан тушаалтнуудын жагсаалт

Үндсэн хариуцагч	Хоёрдогч хариуцагч
Т.БАТБАЯР НУТА-ны дарга Ц/Ш: batbayar.t@ncac.mn Утас: 7128-5086 Б.ТҮВШИНБАТ НХҮА-ны дарга Ц/Ш: ats_office@ncac.mn Утас: 7128-1700	Д.БАЯРТОГТОХ АНҮГ-ын дарга Ц/Ш: bayartogtokh@ncac.mn Утас: 71283000

3.4.2 Шууд хариуцах ажилтнууд

Үйл ажиллагаа	Хариуцагч
Нислэгийн төлөвлөгөө, мэдээлэл дамжуулах нэгж, ажлын байр	НЦХЗХ-ийн дарга, Утас: 71-283330 НЦХЗХ-ийн Нислэгийн урсгал төлөвлөлтийн мэргэжилтэн Утас: 71-282235, 71-282029 Ц/ш: fpd@mcaa.gov.mn
	ШТХ-ийн Нислэгийн төлөвлөлтийн мэргэжилтэн Утас: 71-281602 Ц/ш: tpu@mcaa.gov.mn
Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ	БУҮХ-ийн ЕНХУ, ЭЕНХУ Утас: 71-281614, 71-281618 atc@ncac.mn
	АУҮХ-ийн ЕНХУ, ЭЕНХУ Утас: 71-287121 Буянт-Ухаа цамхаг Утас: 71-281611, tower@ncac.mn Улаанбаатар цамхаг Утас: 71-287271, nubia_atc@ncac.mn Арцат ажлын байр Утас: 71-281635, fic@ncac.mn

	ОУУХ-ийн дарга Утас: 71-281710, 71-281179 approach@ncac.mn

3.5 Хавсралт

Хавсралт 1

Нислэгийн мэдээлэл дамжуулах хуудас

Аяллын дугаар	Нислэг үйлдсэн огноо	Хилээр нэвтэрсэн хаалга	Агаарын замын дугаар	Хилээр гарсан хаалга	Тайлбар

Жич: Цаг агаарын болон онцгой нөхцөл байдлын үе дэх нислэгийн өөрчлөлт хамаарахгүй.

Мэдээлэл бүртгэсэн: АНХУ..... /.....огноо